



**НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2018 оны 02 сарын 26 өдөр

Дугаар A/26

Улаанбаатар хот

Пневмококкийн эсрэг вакцинаар
дархлаажуулах арга хэмжээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулах тухай” А/20 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн Багануур, Багахангай, Баянгол, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн харьяаллын 2 сартай хүүхдийг пневмококкийн эсрэг 13 цэнт вакцинаар дархлаажуулах арга хэмжээг товын дагуу 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулсугай.
2. Пневмококкийн шалтгаант уушгины хатгалгаа өвчнөөс сэргийлэх пневмококкийн эсрэг 13 цэнт вакцинаар дархлаажуулах товыг нэгдүгээр, вакцин хэрэглэх зааврыг хоёрдугаар, сурталчилгааны материал хэвлүүлэх төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Дүүргийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгах нь:
 - 3.1 Дүүрэг, хороо, орон нутгийн засаг захиргааны холбогдох ажилтантай хамтран 2 сартай хүүхдийн судалгааг нарийвчлан гаргах,
 - 3.2 Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин, дагалдах хэрэгслийг өрхийн эрүүл мэндийн төвд цаг хугацаанд нь хуваарилах,
 - 3.3 Дархлаажуулалтын хамралтыг сайжруулж, товоос хоцорсон хүүхдийг нөхөн дархлаажуулах үйл ажиллагааг байнга зохион байгуулах,
 - 3.4 Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины хамралтын цахим програмын талаар ажлын байрны сургалт зохион байгуулах,
 - 3.5 Дархлаажуулалтын нэгжийн үйл ажиллагаа, дархлаажуулалтын явцад дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах,
 - 3.6 Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалтыг эрчимжүүлж, бүртгэгдсэн тохиолдлыг хугацаа алдалгүй мэдээлэх,
 - 3.7 Дархлаажуулалтын тов, ач холбогдлын талаар эрүүл мэндийн ажилтан болон эцэг, эх, асран хамгаалагчдад тогтмол сурталчлах,
 - 3.8 Дархлаажуулалтын хамралтын цаасан мэдээг цахим програмтай тулган тайланг сар бүрийн 05-ны дотор Нийгмийн эрүүл мэндийн хэлтэст цахим хэлбэрээр [/enkheed2000@gmail.com/](mailto:enkheed2000@gmail.com) ирүүлэх.

1150500048


4. Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, удирдлага мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс /О.Энхзаяа/-т даалгасугай.

5. Дархлаажуулалтын ач холбогдлыг эрүүл мэндийн ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлахыг Нийгмийн эрүүл мэнд /О.Энхзаяа/, Захиргаа, төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээ /Г.Баянжаргал/-ний хэлтэст тус тус үүрэг болгосугай.

6. Сурталчилгааны материалд шаардагдах төсвийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Н. Баярхүү/-д зөвшөөрсүгэй.

7. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /О.Баяр/-д даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 02 дугаар сарын 26 өдрийн
12 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ПНЕВМОКОККИЙН ЭСРЭГ 13 ЦЭНТ ВАКЦИНААР ДАРХЛААЖУУЛАХ ТОВ

№	Дархлаажуулах нас	2018 оны 03 дугаар сар	2018 оны 05 дугаар сар	2018 оны 10 дугаар сар
1	2 сар	Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины 1 дэх тунг Тавт вакцины 1 дэх тунтай нэгэн зэрэг		
2	4 сар*		Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины 2 дахь тунг Тавт вакцины 3 дахь тунтай нэгэн зэрэг	
3	9 сар**			Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины 3 дахь тунг Улаанбурхан. Гахайн хавдар, улаануудын эсрэг /УГУ/ вакцины 1 дэх тунтай нэгэн зэрэг

Тайлбар: 2018 оны 03 дугаар сард 2 сартай хүүхдийг эхний тунгаар дархлаажуулна.

* Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины 1 дэх тунд хамрагдсан хүүхэд

** Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины 1 ба 2 дахь тунд хамрагдсан хүүхэд

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 02 дугаар сарын 26 өдрийн
126 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ПНЕВМОКОККИЙН ЭСРЭГ 13 ЦЭНТ ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

НАЙРЛАГА

Пневмококкийн эсрэг 13 цэнт конъюгат вакцин нь *Streptococcus pneumonia* нянгийн 13 дэд хэвшинжийн (1,3,4,5, 6A, 6B, 7F, 9V, 14, 18C, 19A, 19F, 23F) гадаргуугийн эсрэгтөрөгчийн полисахаридууд болон сахуугийн CRM₁₉₇ уураг, сахуугийн хоргүйсүүр, хөнгөнцагааны фосфат болон тарилгын ус агуулсан.

0.5 мл нэг хүн тун вакцинд:

Пневмококкийн (1, 3, 4, 5, 6A, 7F, 9V, 14, 18C, 19A, 19F, 23F) дэд хэвшинжийн полисахаридууд	2.2µg тус бүр
Пневмококкийн 6B дэд хэвшинжийн полисахарид	4.4 µg
Сахуугийн CRM ₁₉₇ уураг	-34 µg
Хөнгөнцагааны фосфат	0.125 мг
Бусад найрлага: Полисорбит 80, Содиум хлорид, тарилгын ус агуулагдана.	

САВЛАЛТ

Пневмококкийн 13 цэнт нь шингэн хэлбэртэй цагаан өнгийн суспенз уусмал.

1 флакон вакцин 0.5мл –1 хүн тунгаар савлагдсан.

ТАРИХ ТУН ХЭМЖЭЭ, ТОВ, БУСАД ВАКЦИНТАЙ ХАРИЛЦАН ҮЙЛЧЛЭЛ

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакциныг 3 тун хийлгэсэн байх шаардлагатай. Эхний тунг 2 сартай, хоёр дахь тунг 4 сартайд, гурав дахь тунг 9 сартайд тус тус хийнэ. Булчинд тарьж хэрэглэнэ. Нярай, 2-8 сартай хүүхдэд гуяны гадна дунд хэсэгт, 9 сараас 2 хүртэлх настай хүүхэд болон насанд хүрэгчдэд гарын бугалганы делтойд булчинд тарьж хэрэглэнэ.

Тарилгын өмнө вакциныг зөөлөн сэгсэрч нэгэн жигд цагаан өнгийн суспенз уусмал болсоны дараа тарилгыг хийнэ. Нэг удаагийн өөрөө эвдэрдэг ариун зүү тариур ашиглан 0.5 мл тунгаар булчинд тарих ба цусны судас, мэдрэлийн судалтай ойр тарихаас болгоомжилно. Вакциныг өгзөгний булчинд тарьж болохгүй.

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакциныг сахуу, хөхүүл ханиад, татран, Хиб, гепатит В, улаанбурхан, улаанууд, гахай хавдар, салхинцэцэг, С хүрээний менингококкт халдварын эсрэг вакцин, халдварт саагийн эсрэг идэвхигүйжүүлсэн вакцинуудтай цуг

хэрэглэж болно. Хэрвээ нэгэн зэрэг хийгээгүй тохиолдолд нэг сарын дараа нөхөн дархлаажуулна. Хүний дархлал хомсдолын вирусийн халдвартай хүнд хийж болно.

Пневмококкийн эсрэг 7 цэнт вакцин хийлгэсэн хүүхдэд:

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин нь (пневмококкийн 7 цэнт вакцинд) агуулагддаг 7 дэд хэв шинжийг агуулсан ба адилхан CRM₁₉₇ уургийг ашиглан конъюгат /нийлмэл/ технологиор үйлдвэрлэсэн.

Өмнө нь пневмококкийн 7 цэнт конъюгат вакцинаар дархлаажуулсан хүүхдийг вакцины товллын дагуу Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцинаар дархлаажуулж болно.

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ ХҮНДРЭЛ

Хэсэг газрын урвал болон халуурах, цочромхой болох, нойрмоглох, тайван бус болох, хоолны дуршил буурах, бөөлжих, суулгах, тууралт гарах зэрэг шинжүүд гарч болно.

ЭСРЭГ ЗААЛТ

Вакцины найрлагад орсон бодис болон сахуугийн хоргүйсүүрт хэт мэдрэг хүүхдэд тарихгүй.

ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ

Вакциныг $+2^{\circ}\text{C}$ / - / $+8^{\circ}\text{C}$ /-д хадгалаж, тээвэрлэнэ.
ХӨЛДӨӨЖ БОЛОХГҮЙ. Хэрэв хөлдсөн бол зохих журмын дагуу устгана.
Үйлдвэрлэсэн: Файзер лимитед сэндвич, Их Британи улс